



“ЭРДЭНЭТ ҮЙЛДВЭР” ХХК-ИЙ  
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ  
Ц. ДАВААЦЭРЭН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН  
ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР  
АЛБАН ШААРДЛАГА**

210646 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Бага тойруу, Засгийн газрын IV байр,  
Утас: 26-04-37, Факс: 32-32-66

2013.12.17 № 148

**ЗӨРЧЛИЙГ АРИЛГАХ ТУХАЙ**

Үндэсний аудитын газрын 2013 оны бүтээгдэхүүн, ажил үйлчилгээний төлөвлөгөөний дагуу “Эрдэнэт үйлдвэр” ХХК-ий 2012 он, 2013 оны эхний 9 сарын санхүүгийн зарим үйл ажиллагаанд эрсдэлийн аудит хийлээ.

Аудитын явцад 2012 оны орлогын 1,182.1 сая төгрөгийн орлогын 4 хуулийн этгээдээс ирсэн мөнгөн орлого, 21,831.7 сая төгрөгийн 71 хуулийн этгээдэд өгсөн мөнгөн зарлага, 2013 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хүртэл 35 хуулийн этгээдэд өгсөн 8,272.5 сая төгрөгийн мөнгөн зарлагын түүвэрлэн авч гүйлгээ хийсэн анхан шатны нотлох баримтыг тулган баталгаажуулахад зөвхөн гэрээг хавсаргасан бөгөөд заримд нь ажил хүлээн авсан акт хавсаргасан байна.

Эдгээр мөнгөн зарлагын гүйлгээнд мөнгөн зарцуулалтыг төсөв, түүний гүйцэтгэлийг тайлагнаагүй, чухам ямар зардлуудад зарцуулсан нь тодорхойгүй, зарцуулалтыг баримтаар тулган шалгасан ажилтангүй, хийсэн ажлаа бүрэн тайлагнаж хүлээлгэн өгөөгүй байхад ажил хүлээн авсан актыг үйлдэж, олон албан тушаалтан гарын үсэг зурсан байна. Мөн хийх ажлын зорилго, ажлын обьём, гарах үр дүн, юу хийж өгөх нь тодорхойгүй бүрхэг гэрээ хийгдсэн байгаа нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.2-д “санхүүгийн тайлан нь үнэн, зөв баримт материал, бодит тоо, мэдээнд үндэслэх;” гэсэн заалтыг зөрчсөн байна.

Төрийн аудитын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.1.12-т “аудитын явцад илэрсэн төлбөр, зөрчлийг барагдуулах акт тавих, албан шаардлага өгөх, хууль тогтоомж, эрх зүйн хэм хэмжээ тогтоосон бусад шийдвэрийг боловсронгуй болгох саналыг холбогдох байгууллагад тавих” гэж заасныг үндэслэн хавсралтад тусгасан нийт 7,565.4 сая төгрөгийн мөнгөн зарлагын гүйлгээний нотлох баримтыг бүрэн бүрдүүлж, хянан зөрчлийг арилгаж, гүйцэтгэлийг гарган 2014 оны 7 дүгээр сарын 30-ны дотор Үндэсний аудитын газарт ирүүлэхийг тус компаний Ерөнхий захирлын Эдийн засаг хариуцсан орлогч захирал Б.Алтанхуяг, Ерөнхий нягтлан бодогч Платонов М.В нарт даалгав.

**ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗРЫН  
АХЛАХ АУДИТОР**

Танилцаж зөвшөөрсөн:

Ерөнхий захирлын Эдийн засаг хариуцсан орлогч захирал

Ерөнхий нягтлан бодогч

Л.ОДГЭРЭЛ

Б.Алтанхуяг

Платонов М.В

070390



**2012 оны мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний нотлох баримт дутуу  
гүйлгээний жагсаалт**

№	Байгууллагын нэр	дүн	хариуцах хүн
1	New Star хогжмийн студи	43,785,000.00	дөлцэцэг
2	Ардчилал сонин	12,000,000.00	дөлцэцэг
3	Гинцветмет институт	24,873,660.00	нямхүү
4	Гипроцветмет г.Москва Сч-1320	1,632,866,200.00	нямхүү
5	Дотоодын цэрэг	10,000,000.00	март
6	Залуусын цахим сулжээ ТББ	14,000,000.00	дөлцэцэг
7	МГУНТИ Информационной Технологии	89,374,189.00	нямхүү
8	ММэргэшсэнНБИинститут	200,900,000.00	дөлцэцэг
9	МН-25 телевиз	20,000,000.00	дөлцэцэг
10	МУИС-ийн ЭЗСургууль	14,000,000.00	дөлцэцэг
11	Мон-ын эхлэлтийн бизнесийг дэмжих холбоо ТББ	15,000,000.00	дөлцэцэг
12	Мон.Гос.. Унив.Науки и Тех.	411,764,120.00	нямхүү
13	МонГУ	56,353,040.00	нямхүү
14	Монгол толботон сэтгуул	23,400,000.00	дөлцэцэг
15	Монголын УУ ундэсний ассоциаци	61,930,000.00	дөлцэцэг
16	Монголын гэрэл зураг мэдээллийгн сэтгуулТББ	15,000,000.00	дөлцэцэг
17	Монголын сайтын холбоо ТББ	25,000,000.00	дөлцэцэг
18	Монголын сонины холбоо	25,000,000.00	дөлцэцэг
19	Монголын талбайн теннисний холбоо	52,408,467.00	дөлцэцэг
20	Монгольский Институт Горного Дела	901,917,600.00	нямхүү
21	Мороодлийн телевиз	15,000,000.00	дөлцэцэг
22	Мэдлэгийн менеж-тийн сургалт,суд-ны тов	144,375,000.00	дөлцэцэг
23	Налоговое бюро	387,660,400.00	
24	ОМА Барилга	95,508,100.00	нямхүү
25	Оллоо ХХК	25,000,000.00	
26	Орон нутгийн сонины холбоо	31,363,636.00	дөлцэцэг
27	Орос дууны монгол ноход ТББ	10,000,000.00	
28	РТТМ ББН	10,796,685.00	
29	Севиллиа АудитХХК	744,020,000.00	
30	Сэтгуу лчдийн Оюуны Голомт ТББ	25,000,000.00	нямхүү
31	Сэтгуулчдийн оюуны голомт ХХК	27,000,000.00	люба
32	Сэтгэл судлалын ундэсний тов ТББ	17,140,000.00	дөлцэцэг
33	УГГГ академия	108,968,141.00	
34	Улаанбаатар телевиз ХХК	20,000,000.00	дөлцэцэг
35	ХАНДИВ ТУНГАЛАГ	12,264,000.00	бямба
36	Хандив Цогтэрдэнэ	29,186,261.00	бямба
37	Хэрэглэгчдийн эрх ашгийг хам/х нийгэмлэг Орхон	13,200,000.00	дөлцэцэг
38	Цогц харилцаа тов ТББ	13,636,363.00	дөлцэцэг
39	Чолоот хэвлэл сан	34,020,000.00	дөлцэцэг
40	ШУТИС Барилгын Инженер архитектурын Сургууль	34,787,790.00	нямхүү
41	ШУТИС йин харьяа КТМС	24,980,000.00	нямхүү
42	Шинэ дэлхий телевиз	35,000,000.00	дөлцэцэг
43	ЭМШУИС-ийн Шанд сан	155,250,000.00	дөлцэцэг
44	ЭЭН ХХК	512,649,966.00	нямхүү
45	Эрдэнэт-Тисса не использовать!!!	90,904,570.00	март
	<b>НИЙТ ДҮН</b>	<b>6,267,283,188.00</b>	

**2013 оны мөнгөн хөрөнгийн зарлагын гүйлгээний нотлох баримт дутуу  
гүйлгээний жагсаалт**

<b>№</b>	<b>Байгууллагын нэр</b>	<b>дүн</b>	<b>хариуцах хүн</b>
1	Ардчилал сонин	20,000,000.00	Дөлцэцэг
2	Батуудын эхлэл ХХК EBS телевиз	10,000,000.00	Дөлцэцэг
3	Залуучуудын холбоо	18,600,000.00	Дөлцэцэг
4	МГГУ	16,707,427.00	нямхүү
5	ММэргэшсэнНБИНститут	86,100,000.00	Дөлцэцэг
6	МСЭ-ийн Орхон аймгийн салбар	20,000,000.00	Дөлцэцэг
7	Мон.Гос.. Унив.Науки и Тех.	60,164,000.00	нямхүү
8	Монголын орчин ход-ийн э/м-ийн нийгэмлэг ТББ	17,500,000.00	Дөлцэцэг
9	Монголын талбайн теннисний холбоо	61,576,788.00	Дөлцэцэг
10	Мэдлэгийн менеж-тийн сургалт,суд-ны төв	30,000,000.00	Дөлцэцэг
11	Налоговое бюро	211,470,000.00	Дөлцэцэг
12	Нар туссан цаг ХМХ	13,800,000.00	Дөлцэцэг
13	Предс-во УБг Расчет по поставщикам	82,191,120.00	бямба
14	Ситиблессинг ХХК MBS телевиз	15,000,000.00	Дөлцэцэг
15	Сэтгэл судлалын ундэсний тов ТББ	17,140,000.00	Дөлцэцэг
16	УГГГ академия	50,952,041.00	нямхүү
17	Ундэсний газарзүй сэтгуул	14,841,250.00	Дөлцэцэг
18	Хандив Цогтэрдэнэ	21,204,000.00	
19	ЭЭН ХХК	380,864,916.00	нямхүү
20	Эрдэнэт сан	150,000,000.00	
	<b>нийт дүн</b>	<b>1,298,111,542.00</b>	